



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР
**ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**

Улсын Их Хурлын тамгын газрын 1 дүгээр байр,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976-51) 26 45 36,
Цахим шуудан: prd.institute@parliament.mn,
Цахим хуудас: www.research.parliament.mn

2026.02.16 № 176-01/0053

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАЯРМАА ТАНАА

Таны 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн
Хуулийн төсөлд зардлын тооцоо хийлгэх тухай
албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Санал
худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны
тайлан”-г үүгээр хүргүүлж байна.

Хувийг: Монгол Улсын Их Хурлын Ерөнхий
нарийн бичгийн дарга Л.Өлзийсайханд.

ЗАХИРАЛ



Д.БУМДАРЬ

1526030073



МОНГОЛ УЛСЫН ДХХУ РҮЛНГ-ЛЭГЧ ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

САНАЛ ХУДАЛДАН АВАЛТЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Судалгааны төрөл:
Судалгааны код:
Хугацаа:

Зардлын тооцоо
ЗТ 26/101
2026-02-06

ЗАХИАЛАГЧ:

УИХ-ын гишүүн Ж.Баярмаа

Хянасан:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр (Ph.D)
Судалгааны хэлтсийн дарга Э.Дашзэгвэ

Судалгаа удирдсан:

Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ

Судлаач:

Б.Мөнхзориг

Улаанбаатар хот
2026

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	ii
Удиртгал.....	3
Санал худалдан авалтын эсрэг хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо	5
1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо	5
1.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа	5
1.2. Ажлын хөлсийг тооцох.....	5
1.3 Тоон үзүүлэлтийг тооцох	6
1.4 Нийт зардал.....	6
2. Иргэний зардлын тооцоо.....	6
2.1. Иргэний гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг тогтоох.....	6
2.2. Тоон үзүүлэлт ба ачаалал.....	7
3. Төрийн байгууллагын зардлын тооцоо	8
3.1 Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа	8
3.2. Хүний нөөцийг тодорхойлох.....	10
3.3 Нэмэгдэх ажлын ачаалал.....	13
3.4. Гарах зардлыг урьдчилан тооцох	17
3.5. Нийт зардлыг тооцох	20
3.6 Хялбарчлах боломжийг шалгах	21
Дүгнэлт.....	22
Ашигласан материал	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, стандарт арга хэмжээ, шаардагдах хугацаа.....	5
Хүснэгт 2. Иргэний гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа, шаардагдах хугацаа.....	6
Хүснэгт 3. Төрийн байгууллагын үүрэг, стандарт үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ	8
Хүснэгт 4. Хүний нөөцийн хэрэгцээ	10
Хүснэгт 5. Жилд шаардагдах хугацаа ба нэмэгдэх ачаалал.....	13
Хүснэгт 6. Төрийн байгууллагад ногдох материаллаг зардал	17
Хүснэгт 7. Авлигатай тэмцэх газар, Олон нийтийн зөвлөлөөс гарах зарим зардлууд...	18
Хүснэгт 8. Нэг удаагийн сургалт, хэлэлцүүлгийн зардлын задаргаа	19
Хүснэгт 9. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал.....	20
Хүснэгт 10. Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардал, 2026-2027	20

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргана" гэж заасан байдаг. Энэ хүрээнд Санал худалдан авалтын эсрэг хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" (цаашид "аргачлал" гэх)-ыг баримтлан Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Санал худалдан авалтын эсрэг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь санал худалдан авах бүх хэлбэрийг хориглох, санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, олон нийтийн оролцоо, хяналтыг дэмжих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заажээ.

Хууль санаачлагчаас Санал худалдан авалтын эсрэг хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон байна:

"Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт "Монголын ард түмэн бид эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.", 3.2 дахь хэсэгт "Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно." гэж, 16 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт Монгол Улсын иргэн "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй..." гэж, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус хуульчилсан.

Үндсэн хуульд заасан эрхэм зорилгод хүрэхийн тулд Үндсэн хуулийн биелэлт, хэрэгжилтийг хангах асуудал чухал юм. Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийг удирдах эрхээ иргэд чөлөөтэй эдлэх, хэрэгжүүлэхэд улс төрийн эрх мэдлийг хувийн болон бүлгийн явцуу ашиг сонирхол, хүсэл зорилгодоо ашиглах, сонгогчдын санал худалдан авах үйлдэл нь илтэд нөлөөлөх болжээ.

Сонгогчдын саналыг худалдан авах үйлдэл нь хууль бус үйлдэл бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдал, шударга ёс, эрх зүйт төрд харш үзэгдэл юм. Улс төрийн сонгуулийн авлигажсан байдал, хууль зөрчиж сонгогчдын саналыг худалдан авах үйл явц эцэстээ чөлөөт, ардчилсан сонгуулийн ач холбогдлыг багасгаж, улс төрийн намыг авлигад автуулж, төрийн бүтэц данхайж, улсын төсөв, хөрөнгө оруулалт нэмэгдсэн ч иргэдэд үзүүлэх бодит үр ашиг, үйлчилгээний чанар суларч, гажуудсан ардчилалд хүргэдэг нийтлэг үзэгдэл юм."

Судалгааны зорилго: Хуулийн төсөл хэрэгжсэнээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын хэмжээ, цаг хугацааны ачааллыг тооцож, төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны ажлын бүтэц: Хуулийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, зардлын тооцоог дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо;
2. Иргэнд үүсэх зардлын тооцоо;
3. Төрийн байгууллагын зардлын тооцоо.

Судалгааны арга зүй: Зардлын тооцооллыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэсэн.

**САНАЛ ХУДАЛДАН АВАЛТЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ТӨСГӨЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТОС ЦОО**

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо

1.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан нь хуулийн үйлчлэлд хамаарах этгээд байхаар заасан байна.

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, үйлдэл буюу стандарт үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг Хүснэгт 1-д тодорхойлов. Хугацааг тодорхойлохдоо стандарт үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний цаг хугацаа зарцуулахыг минутаар тооцоолж гаргана. Тухайн судалгаанд стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг тооцохдоо аргачлалд заасан "Хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвар"-ыг баримталлаа.

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг, стандарт арга хэмжээ, шаардагдах хугацаа

Хуулийн этгээдийн үүрэг	Ерөнхий үйл ажиллагаа	Стандарт үйл ажиллагаа	Шаардагдах хугацаа/мин/	Давтамж
8.1.3 Санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	700	Жилд 1 удаа
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх		
		Олшруулах, архивлах, тараах		
	Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	960	Жилд 1 удаа
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд		
Нийт			1660 мин	

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

1.2. Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тооцохдоо төрийн өмчит хуулийн этгээдийн сарын дундаж цалин хөлсийг үндэслэж тооцох бөгөөд стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн ур чадвар шаардлагагүй гэж үзэв. Үндэсний статистикийн хороо (цаашид ҮСХ гэх)-ноос 2025 оны 12 дугаар сарын байдлаар гаргасан мэдээгээр ажиллагчдын сарын дундаж цалин төрийн өмчийн хуулийн этгээд 3,384.3 мянга, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийнх 3,311.2 мянган төгрөг буюу дунджаар 3,347.7 мянган төгрөг байна.

Эндээс нэг минутад ногдох ажлын хөлсний дундаж хэмжээг сарын цалин хөлснөөс тооцвол (сард 168 цаг/10080 мин):

$$\text{Ажлын хөлс} = \text{Үндсэн цалин} \div \text{Сард ажиллах хугацаа} = 3,347.7 \text{ мян.төг} \div 10080 \text{ мин} = 332 \text{ төг}$$

$$\text{Зардал}_1 = 700 \text{ мин} * 332 \text{ төг} = 232,5 \text{ мян. төг}$$

$$\text{Зардал}_2 = \text{Зарцуулах хугацаа} * \text{Ажлын хөлс} = 960 \text{ мин} * 332 \text{ төг} = 318,8 \text{ мян.төг}$$

1.3 Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлтийг тооцоход тухайн үүргийг холбогдох хуулийн этгээд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн 1 жилээр тооцох буюу Тохиолдлын тоог Давтамжийн тоогоор үржүүлж тооцно.

Тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ. ҮСХ-ны мэдээгээр 2025 онд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн 5,517 хуулийн этгээд байна. Үүнээс 2023 оны судалгаагаар 54 орчим хувь нь ашигтай ажилласан байгааг харгалзан тооцвол ойролцоогоор **2980** хуулийн этгээд голлон хэрэгжүүлэхээр тооцов.

Давтамжийг хуулийн төсөлд шууд тусгаагүй тул стандарт үйл ажиллагаа бүрийг жилд нэг удаа буюу стандарт үйл ажиллагаа нийтдээ 2 удаа зохион байгуулагдахаар тооцлоо:

$$\text{Тоон үзүүлэлт} = \text{Тохиолдлын тоо} \times \text{Давтамжийн тоо} = 2980 \times 2 = 5960$$

1.4 Нийт зардал

Санал худалдан авалтын эсрэг хуульд зааснаар хуулийн этгээдэд үүсэх нийт зардлын дүнг тооцохдоо тухайн үйл ажиллагаа бүрд шаардагдах зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлсний нийлбэрээр тооцов:

$$\text{Нийт зардал} = \text{Зардал} \times \text{Тоон үзүүлэлт} = (232,5 \text{ мян.төг} \times 2980) + (318,8 \text{ мян.төг} \times 2980) = 1,642,9 \text{ сая.төг}$$

Нийт зардлын хэмжээ жилд ойролцоогоор **1,642,897,059.52** (~нэг тэрбум зургаан зуун дөчин сая) төгрөг байгаа боловч энэ нь сонгуулийн шударга байдлыг хангах, төрийн нөөцийг зохисгүй ашиглахаас сэргийлснээр гарах нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй харьцуулахад харьцангуй бага гэж үзэж байна.

2. Иргэний зардлын тооцоо

Аргачлалын гуравдугаар хэсэгт иргэний зардлыг тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэнд үүсэх ачааллыг голлон тооцох бөгөөд шаардлагатай тохиолдолд зайлшгүй гарах нэмэлт зардлыг тооцож гаргаж болно гэж заасан. Хуулийн төсөлд туссанаар иргэний хувьд санал худалдан авалтын аливаа үйлдэлд өртсөн бол заавал мэдээлэх үүрэг хүлээж байгаа бөгөөд мэдээллийг мэргэжлийн зөвлөгөөнд үндэслэн бэлтгэх, холбогдох газарт илгээх, эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөхөд цаг хугацааны ачаалал үүснэ гэж үзэж байна.

2.1. Иргэний гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг тогтоох

Хуулийн төслийн 11.2-т Иргэн санал худалдан авалтын аливаа үйлдэлд өртсөн бол заавал мэдээлнэ, гэж заасан байна. Аргачлалын дагуу иргэний гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас), мэдээллээ холбогдох газарт илгээх, эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөх стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Иргэний гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа, шаардагдах хугацаа

Иргэний гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх жишиг хугацаа
-------------------------	------------------------	-------------------------

11.2 Иргэн санал худалдан авалтын аливаа үйлдэлд өртсөн бол заавал мэдээлнэ	Мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас)	30
	Мэдээллээ холбогдох газарт илгээх	5
	Эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөх	15
НИЙТ		50

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

2.2. Тоон үзүүлэлт ба ачаалал

Санал худалдан авалтын аливаа үйлдэлд өртсөн мэдээллийг хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасны дагуу Авлигатай тэмцэх газар, 14 дүгээр зүйлд заасны дагуу Олон нийтийн зөвлөлд мэдээлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохын тулд Монгол Улсын хувьд санал худалдан авалтын магадлалыг тооцох шаардлагатай бөгөөд дараах өгөгдлүүдийг ашиглалаа:

1. Олон улсын харьцуулсан үзүүлэлт (Global Benchmarks)

Transparency International¹ болон World Justice Project² зэрэг байгууллагуудын судалгаагаар хөгжиж буй орнуудад сонгогчдын 15%-оос 40% нь ямар нэг байдлаар санал худалдан авах оролдлогод өртдөг гэсэн дүгнэлт байдаг.

Зүүн өмнөд Ази болон Латин Америк зарим орнуудад (жишээ нь Филиппин, Мексик) сонгогчдын 20-30% нь бэлэн мөнгө эсвэл бэлэг хүлээн авсан гэж мэдээлсэн байна.

Манай улсын хувьд Азийн сангаас гаргадаг “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг”³ судалгаагаар иргэдийн дийлэнх нь сонгуулийн шударга байдалд эргэлздэг бөгөөд санал худалдан авалтыг “түгээмэл” үзэгдэл гэж үздэг.

2. Монгол Улсад санал худалдан авалтад өртөх магадлалтай бүлэг (Target Estimation)

Хуулийн төслийн танилцуулгад дурдсанчлан 2024 оны сонгуулийн үед ирсэн 1260 гомдол бол зөвхөн “илэрсэн” хэсэг юм. Статистик магадлалын онолоор (Dark Figure of Crime) далд хэлбэрийн зөрчил нь илэрсэн тохиолдлоос 5-10 дахин их байдаг байна.

Хэрэв Монгол Улсын сонгогчдын тоог ойролцоогоор 2 сая⁴, ядуурлын түвшин 27 хувь гэж үзвэл хамаарал бүхий бүлгийн өндөр эрсдэлтэй бүлэг сонгогчдын 15-20 хувь буюу ойролцоогоор 330,000 - 440,000 иргэн санал худалдан авалтын шууд болон шууд бус (бэлэг, арга хэмжээ, халамж амлах) нөлөөнд өртөх магадлалтай байна (УБЕГ, 2024).

Хэдийгээр 330,000 орчим иргэн санал худалдан авалтад өртөх магадлалтай ч ихэнх хэсэг далд хэвээр үлдэх эрсдэлтэй байна. Мөн өмнөх сонгуулийн үед ирүүлсэн гомдлын тоог харгалзаж, шинээр хэрэгжиж эхлэх мөнгөн урамшууллыг авах сонирхол үүсэж мэдээлэл гаргах тоо нэмэгдэнэ гэж үзвэл ойролцоогоор 2000 иргэнээс мэдээлэл ирнэ гэж тооцох үндэслэлтэй байна. Иргэн мэдээлэл гаргахад 50 минут зарцуулна гэж тооцон дараах байдлаар ачааллыг тооцов:

¹ Transparency International (2020). Global Corruption Barometer: Asia 2020. Berlin, Germany.

² World Justice Project (2024). Rule of Law Index 2024. Washington, DC.

³ Asia Foundation (2018). Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа. Хандах: https://asiafoundation.org/wp-content/uploads/2018/09/SPEAK-Survey_2018_mn.pdf

⁴ УБЕГ (2024). Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын тоон мэдээлэл. Хандах: <https://burtgel.gov.mn/post/65600>

Ачаалал=Цаг хугацаа×Тоон үзүүлэлт= 50 мин* 2000= 10000 мин буюу 167 цаг

3. Төрийн байгууллагын зардлын тооцоо

3.1 Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

Хуулийн төслийн 7-14 дүгээр зүйлд Улсын Их Хурал, Засгийн газар болон түүний харьяа байгууллага, бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, түүний гишүүний болон Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо, түүний дэргэд байгуулагдах Олон нийтийн зөвлөлийн хүлээх үүргийг тусгайлан заасан. Эдгээрээс тухайн үүргийг гүйцэтгэхэд зардал гарах шаардлагатай үүрэг, үйл ажиллагаа, түүнд зарцуулагдах хугацааг тодорхойлж Хүснэгт 3-т харуулав.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 46.1-т заасны дагуу УИХ-ын холбогдох байнгын хороо Тамгын газартай хамтран хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах нийтлэг үүргийг давхар тусгав.

Хүснэгт 3. Төрийн байгууллагын үүрэг, стандарт үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Ерөнхий үйл ажиллагаа	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа/мин/
Улсын Их Хурал	7.1.4 Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг жил бүр хийх, тайланг сонсох, шаардлагатай арга хэмжээ авах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын хөндлөнгийн үнэлгээг хийх	Хуулийн хэрэгжилтийн мэдээлэл цуглуулах	2,400
			Хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт (KPI) тогтоох	600
			Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлан боловсруулах	4,800
			Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	300
	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200
			Мэдээлэл нийтлүүлэх	300
			Материал олшруулах, тараах	600
		Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480
			Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480
Засгийн газар,	8.1.3 Санал худалдан авалтаас		Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200

түүний харъяа байгууллага, тэдгээрийн албан тушаалтан	урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	Мэдээлэл нийтлүүлэх	300
			Материал олшруулах, тараах	600
		Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480
			Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480
Бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгч дийн хурал	9.1.4 Санал худалдан авалттай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үүрэг хүлээнэ	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200
			Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	300
			Материал олшруулах, тараах	600
		Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480
Авлигатай тэмцэх газар	13.5 Санал худалдан авалттай холбоотой гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийг шаардлагатай тохиолдолд хамгаалах арга хэмжээг авна	7.1.3.биечилсэн хамгаалалт;	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авах	240
		7.1.5.нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;	Гав, хүлэг, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай буу олгох, харилцаа холбооны хэрэгслээр хангах	120
		7.1.6.аюулгүй газарт түр байрлуулах;	Аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах	720
		7.1.7.нүүлгэн шилжүүлэх;	Мэдээлэгч иргэн, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэх	720
	13.6 Санал худалдан авалттай холбоотой асуудлаар мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл нь үнэн бодитой нь тогтоогдсон	Мөнгөн урамшуулал олгох	УИХ-ын холбогдох байнгын хорооноос баталсан журмын дагуу мөнгөн урамшуулал олгох	600

	тохиолдолд мөнгөн урамшуулал олгоно.			
Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулагдах Олон нийтийн зөвлөл	14.2.2 Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг иргэд, хуулийн этгээдэд сурталчлах, хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах	Сурталчилгаа, соён гэгээрүүлэх	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200
			Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	300
			Материал олшруулах, тараах	600
		Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480
			Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480
	14.3 Олон нийтийн зөвлөл 25 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөлөл болох иргэнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны томилгооны сонсголоор 4 жилийн хугацаагаар томилно.	Олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, хэрэгжүүлэх	Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох	300
			Хэлэлцүүлэг, сургалт, сурталчилгаа, Мэдээлэл хүргэх, хэвлэмэл материал түгээх	2880
			Хөндлөнгийн хараат бус судалгаа, дүн шинжилгээ хийх	4,800

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

3.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тоо /цаашид "тохиолдлын тоо" гэх/-г нэг ажилтанд шаардагдах нийт ажлын цагийн хамт тооцож гаргана. Тохиолдлын тоо буюу хэдэн байгууллага тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхийг тооцохдоо аргачлалын 4.3.2-т "байгууллагыг сонгохдоо тухай ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгоно" гэснийг үндэслэл болгов (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ/мин/
Улсын Их Хурал	7.1.4 Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг жил бүр хийх, тайланг сонсох,	Хуулийн хэрэгжилтийн мэдээлэл цуглуулах	2,400	1	2400
		Хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт (KPI) тогтоох	600	1	600

	шаардлагатай арга хэмжээ авах	Мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайлан боловсруулах	4,800	1	4800
		Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	300	1	300
	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200	1	1200
		Мэдээлэл нийтлүүлэх	300	1	300
		Олшруулах, архивлах, тараах	600	1	600
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480	1	480
Засгийн газар, түүний харьяа байгууллага, тэдгээрийн албан тушаалтан	8.1.3 Санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	1	480
		Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200	16 ⁵	19200
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	300	16	4800
		Олшруулах, архивлах, тараах	600	16	9600
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480	16	7680
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	16	7680
Бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9.1.4 Санал худалдан авалттай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үүрэг хүлээнэ	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200	31	37200
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	300	31	9300
		Олшруулах, архивлах, тараах	600	31	18600
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480	31	14880
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	31	14880
Авлигатай тэмцэх газар	13.5 Санал худалдан авалттай холбоотой гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийг шаардлагатай тохиолдолд хамгаалах арга хэмжээг авна	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авах	240	1	240
		Гав, хүлэг, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал	120	1	120

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432004217932> 16 яам

		боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай буу олгох, харилцаа холбооны хэрэгслээр хангах			
		Аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах	720	1	720
		Мэдээлэгч иргэн, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэх	720	1	720
	13.6 Санал худалдан авалттай холбоотой асуудлаар мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл нь үнэн бодитой нь тогтоогдсон тохиолдолд мөнгөн урамшуулал олгоно.	УИХ-ын холбогдох байнгын хорооноос баталсан журмын дагуу мөнгөн урамшуулал олгох	600	1	600
Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулагдах Олон нийтийн зөвлөл	14.2.2 Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг иргэд, хуулийн этгээдэд сурталчлах, хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1,200	1	1200
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	300	1	300
		Олшруулах, архивлах, тараах	600	1	600
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480	1	480
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	1	480
	14.3 Олон нийтийн зөвлөл 25 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөлөл болох иргэнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны томилгооны сонсголоор 4	Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох	300	1	300
		Хэлэлцүүлэг, сургалт, сурталчилгаа, Мэдээлэл хүргэх, хэвлэмэл материал түгээх	2880	1	2880
		Хөндлөнгийн хараат бус судалгаа, дүн шинжилгээ хийх	4,800	1	4800

жилийн хугацаагаар томилно.				
НИЙТ				168,420

**21 аймаг, нийслэл, 9 дүүрэг

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжоор үүссэн үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хувьд нийтдээ **168,420** минутын хүний нөөцийн хэрэгцээ үүсэхээр байна.

3.3 Нэмэгдэх ажлын ачаалал

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдрийн ердийн ажлын цагт үндэслэж нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнийг тооцно.

1 жил = ажлын 249 өдөр /Календарын ажлын өдөр/

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хууль/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 249 ажлын өдөр буюу (249 x 8) 1992 цаг буюу (1992 x 60) **119,520 минут** ажиллана.

Эндээс төрийн байгууллагад нэмэгдэх ачааллын хэмжээг тооцохдоо аргачлалын 4.4.7-д заасны дагуу тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдаж байгаа хүний нөөцийн хэрэгцээг хугацаагаар илэрхийлснийг жилд шаардагдах ажлын цагийн хэмжээнд хувааж тооцов (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Жилд шаардагдах хугацаа ба нэмэгдэх ачаалал

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ/мин/	Жилд шаардагдах ажлын цагийн хэмжээ/мин/	Нэмэгдэх ажлын ачаалал
Улсын Их Хурал	7.1.4 Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг жил бүр хийх, тайланг сонсох, шаардлагатай арга хэмжээ авах	Хуулийн хэрэгжилтийн мэдээлэл цуглуулах	2400	119520	0.02
		Хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт (KPI) тогтоох	600	119520	0.01
		Мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайлан боловсруулах	4800	119520	0.04
		Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	300	119520	0.003
	Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1.	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1200	119520	0.01

	Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.	Мэдээлэл нийтлүүлэх	300	119520	0.003
		Олшруулах, архивлах, тараах	600	119520	0.01
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480	119520	0.004
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	119520	0.004
		Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	19200	119520	0.16
Засгийн газар, түүний харъяа байгууллага, тэдгээрийн албан тушаалтан	8.1.3 Санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	4800	119520	0.04
		Олшруулах, архивлах, тараах	9600	119520	0.08
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	7680	119520	0.06
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	7680	119520	0.06
		Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	37200	119520	0.31
Бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9.1.4 Санал худалдан авалттай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	9300	119520	0.08

	явуулах үүрэг хүлээнэ	Олшруулах, архивлах, тараах	18600	119520	0.16
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	14880	119520	0.12
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	14880	119520	0.12
Авлигатай тэмцэх газар	13.5 Санал худалдан авалттай холбоотой гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийг шаардлагатай тохиолдолд хамгаалах арга хэмжээг авна	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авах	240	119520	0.002
		Гав, хүлэг, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагча ар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай буу олгох, харилцаа холбооны хэрэгслээр хангах	120	119520	0.001
		Аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах	720	119520	0.01
		Мэдээлэгч иргэн, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол	720	119520	0.01

		түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэх			
	13.6 Санал худалдан авалттай холбоотой асуудлаар мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэл нь үнэн бодитой нь тогтоогдсон тохиолдолд мөнгөн урамшуулал олгоно.	УИХ-ын холбогдох байнгын хорооноос баталсан журмын дагуу мөнгөн урамшуулал олгох	600	119520	0.01
Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулагдах Олон нийтийн зөвлөл	14.2.2 Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг иргэд, хуулийн этгээдэд сурталчлах, хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах	Мэдээлэл цуглуулах, бэлтгэх	1200	119520	0.01
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	300	119520	0.003
		Олшруулах, архивлах, тараах	600	119520	0.01
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	480	119520	0.004
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	480	119520	0.004
	14.3 Олон нийтийн зөвлөл 25 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөлөл болох иргэнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны томилгооны сонсголоор 4 жилийн хугацаагаар томилно.	Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох	300	119520	0.003
		Хэлэлцүүлэг, сургалт, сурталчилгаа, Мэдээлэл хүргэх, хэвлэмэл материал түгээх	2880	119520	0.024
		Хөндлөнгийн хараат бус судалгаа, дүн шинжилгээ хийх	4800	119520	0.04
	НИЙТ			168,420	

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Санал худалдан авалтын эсрэг хуулийн төсөлд туссан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, олон нийт, албан хаагчдад сургалт, сурталчилгаа явуулах, холбогдох мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийг урамшуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд ойролцоогоор **168,420** мин нэмж зарцуулах шаардлагатай бөгөөд ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд нэмэгдэх ачааллыг ажилтны тоогоор илэрхийлвэл **1.41** байна.

3.4. Гарах зардлыг урьдчилан тооцох

Гарах зардлыг аргачлалын дагуу урьдчилан тооцохын тулд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр тооцно. Хүний нөөцийн зардлыг тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох цалин, нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бусад бүх зардлыг нэгтгэн дунджаар тооцно. Хуулийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагуудын цалин, нэмэгдлийн дундаж хэмжээ УИХ-ын Тамгын газар 5,752,002 төгрөг⁶, Засгийн газар, түүний харьяа байгууллага 2,195,706⁷ төгрөг, Аймаг, дүүрэг, нийслэлийн ЗДТГ 2,165,880 төгрөг, Авлигатай тэмцэх газар 5,296,018⁸ төгрөг, Сонгуулийн ерөнхий хороо 4,347,818⁹ төгрөг байгаа бөгөөд дундажлан тооцвол 3,951,485 төгрөг болж байна. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **47,417,821** төгрөг байна гэж тооцов.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Сонгуулийн ерөнхий хороо, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн ЗДТГ-ын материаллаг зардлын дундажид үндэслэн, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэргээр ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. Төрийн байгууллагад ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Улсын Их Хурлын Тамгын газар/1/		5,395,434.00

⁶ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

⁷ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт

⁸ Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

⁹ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 239 дүгээр тогтоолын хавсралт

Засгийн газар, түүний харьяа байгууллага, тэдгээрийн албан тушаалтан /16/	86,326,944.00
Бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал/31/	167,258,454.00
Авлигатай тэмцэх газар/1/	5,395,434.00
Олон нийтийн зөвлөл/25/	134,885,850.00
НИЙТ	399,262,116.00

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Бусад зардалд Авлигатай тэмцэх газар болон Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулагдах Олон нийтийн зөвлөлийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх зардлыг тооцов (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Авлигатай тэмцэх газар, Олон нийтийн зөвлөлөөс гарах зарим зардлууд

Төрийн байгууллага	Зардлын нэр	Тохиолдлын тоо	Хугацаа (мин)	Нэгж зардал	Нийт	Тайлбар
АТГ	Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авах	40	43200	139	480,000,000	40 хүн × 2 албан хаагч × минут
	Гав, хүлэг, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай буу олгох, харилцаа холбооны хэрэгслээр хангах	40	-	1,000,000	40,000,000	Шинээр авах
	Аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулах	40	86400	35	120,000,000	Байр түрээс, хоол, ахуйн зардал

	Мэдээлэгч иргэн, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэх	40	86400	35	120,000,000	Тээвэр, орон байрны дэмжлэг
	УИХ-ын холбогдох байнгын хорооноос баталсан журмын дагуу мөнгөн урамшуулал олгох	1,500	-	1,000,000 ¹⁰	1,500,000,000	2000 мэдээллийн үнэ цэнтэй хэсэгт
Нийт					2,260,000,000	
Олон нийтийн зөвлөл	Зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох	25	-	792,000 ¹¹	237,600,000	25 гишүүн × 12 сар
	Сургалт, хэлэлцүүлгийг 21 аймаг, нийслэлд иргэд, олон нийтэд зохион байгуулах	22		5,980,000	131,560,000	Танхим түрээс, хоол, цай кофе г.м
Нийт					369,160,000	
ДҮН					2,629,160,000	

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Олон нийтийн зөвлөлөөс зохион байгуулах сургалт, хэлэлцүүлгийг иргэд, хуулийн этгээд, олон нийтэд нэг удаа зохион байгуулахад шаардагдах зардлын задаргааг Хүснэгт 8-д харууллаа.

Хүснэгт 8. Нэг удаагийн сургалт, хэлэлцүүлгийн зардлын задаргаа

№	Зардлын төрөл	Тооцоолол	Дүн (₮)
1	Танхим түрээс	1 өдөр	500,000
2	Дуу, дүрс, техник	Проектор, микрофон	300,000
3	Сургалтын материал хэвлэх	40 хүн × 15,000₮	600,000
4	Гарын авлага, тараах материал	40 × 10,000₮	400,000
5	Оролцогчдын цай, кофе, ус	40 × 12,000₮	480,000
6	Үдийн хоол	40 × 25,000₮	1,000,000

¹⁰ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 35-р зүйлийн дагуу олгож байгаа гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл төлбөртэй авч байгаа үнэлгээ (50,000-2,000,000 төгрөг)-г дундажлан тооцов: <https://criminal.police.gov.mn> а 240

¹¹ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2025 оны 4 дүгээр сарын 1-нээс ХНТГТҮХ-ны 2024 оны 10 сарын 7-ны 3 дугаар тогтоол

7	Илтгэгч / сургагчийн хөлс	2 хүн × 400,000₮	800,000
8	Сургагчийн томилолт (орон нутагт)	Зам + байр	1,200,000
9	Зохион байгуулалтын зардал	Бэлтгэл, бүртгэл	400,000
10	Сурталчилгаа, зар	Постер, сошиал	300,000
Нийт			5,980,000

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

3.5. Нийт зардлыг тооцох

Нийт зардлыг тооцохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын 4.6-д заасны дагуу өмнө тооцож гаргасан хүний нөөц, материаллаг болон бусад зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж тооцов (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Төрийн байгууллагад үүсэх нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)	Бусад	Нийт
Төрийн байгууллага	1.41	47,417,822	399,262,116	2,629,160,000	4,336,934,312
Нийт					4,336,934,312

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр хуулийн үйлчлэлд хамаарах төрийн байгууллагууд, түүний албан хаагчдын хүний нөөцийн цалингийн зардалд жилд нийт 47,417,822 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 399,262,116.00 төгрөг, бусад мөнгөн урамшуулалд 2,629,160,000, олон нийтийн сургалт, хэлэлцүүлэг, орон тооны бус зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 369,160,000 төгрөг, нийт 4,336,934,312 (~дөрвөн тэрбум гурван зуун гучин зургаан сая) төгрөгийн зардал үүсэхээр байна.

Дээрх зардлын улсын төсөвт ирэх ачааллыг төсвийн ерөнхийлөн захирагчаар 2026 оны батлагдсан урсгал зардалд үндэслэн 2027 оны төсөөллөөр тооцсоныг Хүснэгт 10-т харууллаа.

Хүснэгт 10. Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардал, 2026-2027

Төсвийн ерөнхийлөн захирагч	2026 онд батлагдсан урсгал зардал/сая төг/	2027 онд шаардлагатай зардал/сая төг/	2027 оны урсгал зардал/сая төг/
Монгол Улсын Их Хурлын дарга	145,444,181.9	11.8	145,444,193.7
Авлигатай тэмцэх газрын дарга	50,499,238.1	2,266.6	50,501,504.7
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	13,466,420.6	508.9	13,466,929.5
16 Сайд, Аймаг, Нийслэл, Дүүргийн засаг дарга	16,987,384,985	285	16,987,385,270

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Санал худалдан авалтын эсрэг хуулийн төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын Нэгдсэн төсвийн зарлага нийтдээ 4.3 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

3.6 Хялбарчлах боломжийг шалгах

Аргачлалын 4.7-д заасны дагуу хуулийн хэрэгжилттэй холбоотой гарах зардлыг бууруулах, давхардлыг арилгах, захиргааны ачааллыг багасгах боломжит хувилбаруудыг судалж үзэв.

1. Сургалт, хэлэлцүүлгийн зардлыг бууруулах боломж

Олон нийтийн зөвлөл болон төрийн байгууллагуудын зохион байгуулах сургалт, хэлэлцүүлгийг зөвхөн танхимаар зохион байгуулахын оронд дараах хосолмол хэлбэрийг ашиглах боломжтой. Үүнд:

- Аймаг, дүүргийн төвд нэг танхим + цахим оролцоо;
- Сургалтын агуулгыг нэг удаа мэргэжлийн түвшинд бэлтгэж, олон удаа ашиглах;
- Хэвлэмэл материалын оронд QR код, цахим гарын авлага боловсруулж ашиглах;

2. Материаллаг зардлыг бууруулах боломж

- Шинээр техник, тоног төхөөрөмж худалдан авахын оронд төрийн байгууллагуудын хуучин нөөцийг ашиглах;
- Орон нутгийн сургалтыг ЗДТГ, ИТХ-ын хурлын танхимд зохион байгуулах;
- Хэвлэмэл тараах материалын тоог хязгаарлаж, цахимаар түгээх.

3. Гэрч, мэдээлэгчийг хамгаалах зардлыг оновчтой болгох боломж

Биечилсэн хамгаалалт, түр байраар хангах үйл ажиллагааг эрсдэлийн түвшнээс хамаарч ховор тохиолдолд хэрэглэх. Тухайлбал, эрсдэл бага үед холбоо харилцааны сувгийг нууцлах, зөвлөгөө өгөх, эрсдэл дунд үед цагдаагийн хяналт тавих, техник хэрэгслээр хангах, эрсдэл өндөр үед биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэх, түр байраар хангах боломжтой.

4. Мөнгөн урамшууллын зардлыг бууруулах боломж

Мөнгөн урамшууллын дээд хязгаарыг бууруулах замаар зардлыг бууруулах боломжтой.

5. Судалгаа, үнэлгээний зардлыг бууруулах

Хөндлөнгийн судалгааг жил бүр биш 2 жил тутамд хийх замаар зардлыг бууруулах боломжтой.

ДҮГНЭЛТ

Санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомж хэрэгжсэнээр төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд тодорхой хэмжээний захиргааны болон санхүүгийн ачаалал үүсэхээр байна. Хуулийн этгээдийн хувьд хуулийг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд 1660 минут зарцуулж, үүнд 1,6 орчим тэрбум төгрөг нэмж шаардагдахаар байна. Иргэнд үүсэх ачаалал санал худалдан авалтын аливаа үйлдэлд өртсөн бол заавал мэдээлэх үүргийн хүрээнд нэг иргэнд 50 минут, нийт 10000 орчим минут байхаар байна. Төрийн байгууллагын хувьд хүний нөөцийн нэмэгдэл ачаалал 1.41 орон тоотой тэнцэх хэмжээтэй, нийт зардлын дүн жилд ойролцоогоор 4.15 тэрбум төгрөг болж, энэ хэмжээгээр төсөвт ачаалал нэмэгдэхээр байна. Үүний дийлэнх хувийг мэдээлэгчийг хамгаалах арга хэмжээ болон мөнгөн урамшуулал бүрдүүлж байна.

Хуулийн хэрэгжилтийг шууд өргөн бүтэцтэй, өндөр зардалтай хэлбэрээр эхлүүлэхээс илүүтэйгээр эрсдэлд суурилсан хэрэгжилтийн загвар, цахимжилтад тулгуурласан сурталчилгаа, байгаа хүний нөөц, дэд бүтцийг ашиглах, үр дүнд суурилсан санхүүжилтийн механизм нэвтрүүлэх нь төсвийн дарамтыг бууруулахын зэрэгцээ хуулийн зорилгод хүрэх үр нөлөөг хадгалах боломжтой гэж дүгнэв.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Хууль тогтоомжийн тухай хууль (2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"
- Transparency International (2020). *Global Corruption Barometer: Asia 2020*. Berlin, Germany.
- World Justice Project (2024). *Rule of Law Index 2024*. Washington, DC.
- https://asiafoundation.org/wp-content/uploads/2018/09/SPEAK-Survey_2018_mn.pdf
- <https://buritel.gov.mn/post/65600>
- https://www.1212.mn/mn/statcate/table-view/Society.%20development/Poverty%2C%20inequality.%20and%20minimum%20subsistence%20level/DT_NSO_1900_007V12.px
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт
- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 239 дүгээр тогтоолын хавсралт